



2025 оны III улирал

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Орхон аймаг

Нэг.Эх хүүхдийн эрүүл мэнд


Төрөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар 1436 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 37 төрөлтөөр буюу 0.5 хувиар буурч,төрсөн эхчүүдийн 1355 нь буюу 94.4 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс удаа хамрагдсан нь өмнөх оноос 18.2 хувиар өссөн байна. Нийт төрөлтөд амьгүй төрөлт 8 буюу 0.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор буюу 0.3 хувиар нэмэгпэж,гэрийн төрөлт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна. Орон нутгаас Орхон аймагт ирж амаржиж буй эхчүүдийн 7.0 хувь нь Булган аймаг, 4.5 хувь нь Улаанбаатар хот 3.1 хувь Сэлэнгэ аймаг, 1.4 хувь нь Хөвсгөл, 1.2 хувь нь Архангай аймгууд эзэлж байна.

Орон нутгаас ирж амаржсан эхчүүд бодит тоо

	Архангай	Баянхонгор	Булган	Говь-алтай	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Дархан-уул	Улаанбаатар	Говьсүмбэр	Бүгд	Нийт төрөлтөд
2024.09	20		109	1	4		3	5	2	4	1	54	5	1	2	24	2	3	64	1	305	20.7
2025.09	17	1	100			1	1	3		5	1	45	3	6	1	20	2	6	64		276	19.2

Төрсөн эхчүүд насны ангилал хувиар



Насны хувьд 4.4 хувийг 20 хүртэлх насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 19 тохиолдлоор буюу 1.4 хувиар нэмэгдсэн, 25.7 хувийг 35-аас дээш насны төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор буюу 0.4 хувиар буурсан байна.Мэс заслын аргаар төрүүлсэн эх нийт 385 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 54 тохиолдлоор буюу 3.0 хувиар буурсан байна.

Төрөлтийн мэдээлэл

		Төрсөн эх	Амьд төрсөн нярай	Амьгүй төрсөн нярай
2024 оны эхний 9 сарын байдлаар	Орхон аймаг	1473	1485	5
	Аймгуудын дүн	19795	19889	83
	Улсын дүн	43116	43428	223
2025 оны эхний 9 сарын байдлаар	Орхон аймаг	1436	1446	8
	Аймгуудын дүн	18405	18507	78
	Улсын дүн	40425	40733	196

Жирэмсэн,төрөлт,төрсний дараах үеийн хүндрэл

Жирэмсэн,төрөх,төрсний дараах үеийн хүндрэл 1239 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 857 ногдож байна.

Нийт хүндрэлд:

- Жирэмсэн үеийн хүндрэл 69.9 хувь
- Төрөх үеийн хүндрэл 26.5 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл 1.1 хувь
- Жирэмсэн,төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 8.5 хувийг тус тус эзэлж байна.

Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 12.8 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 48.8 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 100 хувьтай тэргүүлж байна.

Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1446 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 39 хүүхдээр буюу 2.6 хувиар буурчээ. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 13.5 өмнөх оны мөн үеэс 0.5 промиллоор буурсан. Амьд төрсөн хүүхдийн 744 буюу 51.5 хувь нь хүү, 702 буюу 48.5 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 106 хүү ногдож, амьд төрсөн 1446 хүүхдээс 46 нярай буюу 3.2 хувь нь 2500 гр-аас доош жинтэй төрж, 12 тохиолдол буюу 0.8 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн.

Амьд төрсөн хүүхэд,эхийн тээлтийн хугацаа,хувиар

Он	Эхийн тээлтийн хугацаа эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн	2500 гр-аас доош жинтэй төрсөн
	22-28 долоо хоногтой	29-32 долоо хоногтой	33-36 долоо хоногтой	37-41 долоо хоногтой	42 долоо хоногоос дээш		
2024 оны эхний 9 сарын байдлаар	0.4	0.9	5.3	93.3	0.07	0.9	5.5
2025 оны эхний 9 сарын байдлаар	0.3	0.6	4.7	94.4	0.0	0.8	3.2

Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 70552 хүүхэд хамрагдсанаас 0.17 хувь нь туранхай, 0.15 хувь нь тураалтай, 0.27 хувь нь өсөлтийн хоцрогдолтой,А амин дэм уусан 5809, Д амин дэм уусан 59460,олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн 2 хүүхэд байна.


Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024, 2025 оны эхний 9 сарын байдлаар эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.

Нялхсын эндэгдэл

2025 оны эхний 9 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 11 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 7.6 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буюу 1.2 промиллоор буурч,нялхсын эндэгдлийн 9 буюу 81.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж 1000 амьд төрөлтөд 6.2 байна. Нярайн эндэгдлийн нийт 9 тохиолдлын 7 буюу 77.8 хувь нь эрт үеийн эндэгдэл,2 буюу 22.2 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл тус тус эзэлж байна.Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 72.7 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг,төрөлхийн тэмбүү,осол гэмтлийн шалтгаант нас баралт тус тус 9.1 хувийг эзэлж байна.

1000 амьд төрөлтөд



	2024 оны эхний 9 сарын байдлаар			2025 оны эхний 9 сарын байдлаар		
	Нялхасын эндэгдэл	Нярайн эндэгдэл	Перинаталь эндэгдэл	Нялхасын эндэгдэл	Нярайн эндэгдэл	Перинаталь эндэгдэл
Орхон аймаг	8.8	6.7	10.1	7.6	6.2	11.8
Аймгуудын дундаж	12.0		9.2	12.9		9.7
Улсын дундаж	12.0	7.5	10.0	14.0	8.8	10.9

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдэж,1000 амьд төрөлтөд 8.3 ногдож байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1 тохиолдлоор буюу 0.5 промиллоор буурсан байна.

Хоёр.Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар нийт 590732 эмчийн үзлэг хийгдсэнээс 34.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 40.9 хувийг өвчний учир амбулаторт 8.0 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 14.9 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 1246 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 0.3 хувь, идэвхитэй хяналт 1.2 хувиар өссөн, өвчний учир амбулаторийн үзлэг 2.2 хувь, гэрийн идэвхтэй үзлэг 0.3 хувиар тус тус буурсан байна. Эмчийн үзлэгийг эмнэлгийн төрлөөр харуулбал: 47.1 хувийг өрхийн эмчийн, 25.9 хувийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн, 14.4 хувийг хувийн хэвшлийн клиникийн, 5.5 хувийг Эрдэнэт медиал төрөлжсөн эмнэлгийн, 5.4 хувийг Эрдэнэт сувиллын, 1.7 хувийг сумын эмчийн үзлэг эзэлж байна.

	ЭМБ-ууд	Нийт үзлэг	Үүнээс					
			Урьдчилан сэргийлэх үзлэг	Нийт үзлэгт эзлэх %	Өвчний учир амбулаторт	Идэвхтэй хяналт	Гэрийн идэвхтэй	Гэрийн дуудлагаар
2024 оны эхний 9 сарын байдлаар	СЭМТ	7187	3004	41.8	780	635	2149	619
	БОЭТ	144686	21141	14.6	111392	12127	3	23
	ӨЭМТ	268780	144308	53.7	12693	24339	85759	1681
	ХХЭМБ	86119	8202	9.5	76714	1177	13	13
	ЭТ сувилал	32670	6620	20.3	24890	1110	49	1
	ЭТ медиал	42946	18187	42.3	24759			
	Аймгийн дүн	582388	201462	34.6	251228	39388	87973	2337
2025 оны эхний 9 сарын байдлаар	СЭМТ	10112	3646	36.1	2601	1105	2191	569
	БОЭТ	153022	32361	21.1	105702	14956		
	ӨЭМТ	278059	145555	52.3	12815	29245	85604	1179
	ХХЭМБ	84906	10481	12.3	73223	1201	1	
	ЭТ сувилал	31855	7209	22.6	23872	727	45	2
	ЭТ медиал	32778	12845	39.2	19933			
	Аймгийн дүн	590732	212097	34.9	241807	47234	87841	1753

Эмчийн үзлэг төрлөөр,хувь



Нэг иргэн дунджаар 5.5 удаа эрүүл мэндийн байгууллагад хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан нь өмнөх оны түвшинд байна.



Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 39764 (60.4%) хүн хамрагдсан бөгөөд 39.2 хувь нь эрэгтэй, 60.8 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.8 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 34280 (82.9%) хүн хамрагдсанаас 39.0 хувь нь эрэгтэй, 61.0 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 1400 (75.3%) хүн хамрагдсан.


		АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ ЭРТ ИЛРҮҮЛЭГ			ЧИХРИЙН ШИЖИН ХАМ ШИНЖ -2 ЭРТ ИЛРҮҮЛЭГ		
		Хамрагдсан хүний тоо	Оношлогдсон артерийн гипертензи	Хамрагда лтын хувь	Хамрагдсан хүний тоо	Оношлогдсон артерийн гипертензи	Хамрагд алтын хувь
2024 оны эхний 9 сарын байдлаар	Орхон	37721	284	74.4	33814	109	66.7
	Улсын дүн	1073711		50.3	881486		65.6
2025 оны эхний 9 сарын байдлаар	Орхон	39764	299	60.4	34280	125	82.9
	Улсын дүн	1123389		51.8	887062		63.7

Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2482 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 43.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 32.2 хувиар буурч,нийт 2477 шинжилгээнээс 2245 буюу 90.6 хувь нь хэвийн гарсан байна.Хөхний эрт илрүүлэг үзлэгт 16440 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 67.2 хувийг эзэлж,өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар буурсан байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтад шинээр 1211 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1201 буюу 99.2 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 0.3 хувиар буурсан. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.8 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 41 буюу 3.4 хувь нь цус багадаалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 26 буюу 2.2 хувь, тэмбүү 9 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.08 хувь тус тус эерэг гарсан байна.

Эрт үеийн жирэмсний хяналт



БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт

		Трихомониаз эерэг	Заг хүйтэн эерэг	Тэмбүү эерэг
2024 оны эхний 9 сарын байдлаар	Орхон аймаг	22	2	7
	Аймгуудын дүн	188	30	184
	Улсын дүн	452	48	529
2025 оны эхний 9 сарын байдлаар	Орхон аймаг	26	1	9
	Аймгуудын дүн	142	20	148
	Улсын дүн	380	43	522

Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар нийт 247 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба өмнөх оны мөн үеэс 92 тохиолдлоор нэмэгдэж, нийт үр хөндөлтөд 20 хүртэлх насны үр хөндөлтийн тохиолдол 28(11.3%), хожуу үр хөндөлт 9(3.6%) эзэлж байна.

Үр хөндөлтийн түвшин

	Үр хөндөлтийн тоо		Үр хөндөлтийн харьцаа (1000 амьд төрөлтөд)	
	2024 оны эхний 9 сарын байдлаар	2025 оны эхний 9 сарын байдлаар	2024 оны эхний 9 сарын байдлаар	2025 оны эхний 9 сарын байдлаар
Орхон аймаг	155	247	104.4	170.8
Аймгуудын дүн	2191	2314	110.2	125.0
Улсын дүн	8895	8983	204.8	220.5

Охидын жирэмслэлт,төрөлт,үр хөндөлт

	Өсвөр насны охидын			
	жирэмслэлтийн коэффициент	жирэмслэлтийн эзлэх хувь	төрөлтийн эзлэх хувь	үр хөндөлтийн эзлэх хувь
2024 оны эхний 9 сарын байдлаар	4.4	3.0	3.0	5.2
2025 оны эхний 9 сарын байдлаар	4.2	3.3	4.4	11.3
Өсөлт бууралт	-0.2	+0.3	+1.4	+6.1

Түргэн тусламжийн дуудлага

10429 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 1.7 хувийг алсын, 8.3 хувийг осол, гэмтлийн дуудлага эзэлж байна.

	Түргэн тусламжийн дуудлага			Алсын дуудлагын эзлэх хувь	Осол,гэмтлийн дуудлагын эзлэх хувь
	Нийт	Алсын дуудлага	Осол гэмтлийн дуудлага		
2024 оны эхний 9 сарын байдлаар	11656	231	1917	2.0	16.4
2025 оны эхний 9 сарын байдлаар	10429	181	868	1.7	8.3
Үзүүлэлт	-1227	-50	-1049	-0.3	-8.1

Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

2024 онд тайлан ирүүлсэн 161 эрүүл мэндийн байгууллагаас хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүсийн оношилгоо эмчилгээний төв 1, өрхийн эрүүл мэндийн төв 8, сумын эрүүл мэндийн төв 1, ортой хувийн клиник 12, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 1, хувийн клиник 52 байна. Аймгийн хэмжээнд 23996 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 154405 ор хоног ашиглаж, ор ашиглалтын хувь 66.2, дундаж ор хоног 6.4 байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

	Орны тоо	Хэвтсэн өвчтөн	Эмчлэгдэж гарсан өвчтөн	Ор хоног	Эмнэлгийн нас баралт	Хоног болоогүй нас баралт	Хоног болоогүй нас баралтын хувь	Үүнээс		Орны фонд ашиглалт	Фонд ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт
								8-24 цагийн дотор нас баралт	8-24 цагийн дотор нас баралтын хувь				
БОЭТ	433	11143	11141	70976	104	33	31.7	14	42.4	163.9	66.2	6.4	25.7
СЭМТ	12	226	232	1619						134.9	54.5	7.0	19.3
ЭТ медикал	38	926	952	3397						89.4	36.1	3.6	25.1
ХХЭМБ	459	1173	11671	78413						170.8	69.0	6.7	25.4
Аймгийн дүн	942	24028	23996	154405	104	33	31.7	14	42.4	163.9	66.2	6.4	25.5

2025 оны эхний 9 сарын байдлаар 10 000 хүн амд дунджаар 88.5 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ногдож байгаа нь өмнөх оны дунджаас 0.9-өөр буурсан байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд


2025 оны эхний 9 сарын байдлаар

№	ӨОУА-10 нэршил	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Нийт тохиолдлын хувь
1	Зүрх-судасны тогтолцооны өвчин	3716	349.3	15.5
2	Амьсгалын тогтолцооны өвчин	3177	298.6	13.2
3	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2788	262.1	11.6
4	Жирэмслэн, төрөлт ба төрсний дараах үе	2303	216.5	9.6
5	Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	1875	176.2	7.8
6	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	1295	121.7	5.4
7	Мэдрэлийн тогтолцооны өвчин	1213	114.0	5.1
8	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	939	88.3	3.9
9	Сэтгэцийн ба аягийн эмгэг	880	82.7	3.7
10	Халдварт ба шимэгчт зарим өвчин	721	67.8	3.0
11	Хавдар	625	58.7	2.6

Халдварт бус өвчлөл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар 10 000 хүн амд ногдох амбулаторийн өвчлөл (48034)-ийн түвшин 4515.0 болж,өмнөх оноос 864.7-оор буурсан байна.

Хүн амын өвчлөлийн тохиолдол
1000 хүн амд



Бүртгэгдсэн нийт өвчлөл
10 000 хүн амд,хүйсээр



Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10 000 хүн амд

2025 оны эхний 9 сарын байдлаар

№	ӨОУА-10 нэршил	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Нийт тохиолдлын хувь
1	Амьсгалын тогтолцооны өвчин	10112	95065	21.1
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	9868	927.6	20.5
3	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	7734	727.0	16.1
4	Зүрх-судасны тогтолцооны өвчин	4424	415.8	9.2
5	Нүд ба түүний дайврын өвчнүүд	3616	339.9	7.5
6	Арьс ба халимны өвчин	3460	325.2	7.2
7	Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	2557	240.3	5.3
8	Мэдрэлийн тогтолцооны өвчин	1697	159.5	3.5
9	Хавдар	1255	118.0	2.6
10	Дотоод шүүрхэл,тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд	1103	103.7	2.3
11	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	827	77.7	1.7

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар нь үзэхэд: нийт амьсгалын тогтолцооны өвчлөл Зэст багт 3033 тохиолдол буюу 30.0 хувь бүртгэгдсэн байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөлд:

- Цочмог бронхит 3348 буюу 33.1%
- Хамрын ба хамрын хамрын ангалын бусад эмгэг 1299 буюу 12.8%
- Цочмог гүйлтэс,тонзиллит 1122 буюу 11.1%
- Уушгины архаг бөглөрөлт өвчин 1080 буюу 10.7%
- Уушгины хатгаа 921 буюу 9.1%

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд:

- Шүд ба дайвар бүүцийн бусад эмгэг 2039 буюу 20.7%
- Шүд цоорох,кариес 1681 буюу 17.0%
- Ходоод ба дээд гэдэс,гастрит ба доуденит 1055 буюу 10.7%
- Цочмог нойр булчирхайн бусад өвчнүүд 1027 буюу 10.4%
- Цөсний замын өвчнүүд 844 буюу 8.6%


Шээс бэлгийн тогтолцооны өвчинд:

- Шээс ялгаруулах тогтолцооны бусад эмгэг 2169 буюу 28.0%
- Үтрээний үрэвсэл 1596 буюу 20.6%
- Бөөрний архаг үрэвсэл 1463 буюу 18.9%
- Цэвэрших үеийн бусад эмгэгүүд 430 буюу 5.6%
- Хөхний эмгэгүүд 256 буюу 3.3% тус тус эзэлж байна.

Хорт хавдрын тэргүүлэх шалтгаан


2025 оны эхний 9 сарын байдлаар 238 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 94 (39.5%) эрэгтэй, 144 (60.5%) эмэгтэй.Элэгний хорт хавдраар 60 тохиолдол шинээр оношлогдсоны 45.0 хувь эрэгтэй, 55.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нийт хорт хавдрын 25.2 хувийг эзэлж байна.

Хорт хавдрын өвчлөлийн бүтэц



Гурав.Хүн амын нас баралт

2025 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд нас баралтын 354 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 41 тохиолдлоор буурч нийт нас баралтын 29.4 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 33 тохиолдол буюу 31.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж, эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор өссөн байна.



Нас баралтын түвшин 1000 хүн амд 8.3 байна. Нас баралтын 3.4 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 40 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 11.3 хувийг эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 14 тохиолдлоор өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 3.8 байна.

Осол гэмтлийн нас баралтын шалтгаан:

	Бүгд	Амиа хорлолт	Бусад хорлогдсон	Зам тээврийн осол	Бусад осол	Тодорхойгүй
2024 оны эхний 9 сараар	26	1	1	2	22	
2025 оны эхний 9 сараар	40	2	1	9	27	1

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд

	Зүрх судасны тогтолцооны өвчин	Хавдар	Гэмтэл хордлого, гадны шалтгаан	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Дотоод шүүрэл,тэжээлийн ба бодисын солилцооны өвчин
2024 оны эхний 9 сарын байдлаар	10.8	14.3	2.5	2.6	1.1
2025 оны эхний 9 сарын байдлаар	11.7	10.3	3.8	2.0	0.8


Нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчин дотор:

2024 оны эхний 9 сараар 151	2025 оны эхний 9 сараар 125
- Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 63 буюу 41.7% - Зүрхний ишеми 44 буюу 29.1% - Зүрхний шигдээс 16 буюу 10.6% - Тархины цус харвалт 12 буюу 7.9%	- Бусад зүрх судасны тогтолцооны өвчин 54 буюу 43.2% - Зүрхний ишеми 24 буюу 19.2% - Зүрхний шигдээс 23 буюу 18.4% - Тархины цус харвалт 9 буюу 7.2%

Хорт хавдрын шалтгаант нас баралт

Хавдраас шалтгаалсан нас баралт 2024 оны мөн үеэс 7 тохиолдлоор буурсан хэдий ч нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр нь үзэхэд 61.7 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж,нас барж байна. 2025 оны эхний 9 сарын байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 30.2 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 12.7, 10 000 эмэгтэй хүн амд 7.6 ногдож, хавдрын төрлийн дийлэнх нь элэг, ходоод, умай хүзүү,уушгины хорт хавдраас болж нас барж байна.

Элэгний хорт хавдрын нас баралт,10 000 хүн амд,хүйсээр



Элэгний хорт хавдар нь хүн амын нас баралтыг өвчлөлөөр тооцоход эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралтын 1-р шалтгаан болсоор байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 3 тохиолдлоор буурсан байна.

Эмгэг судлалын шинжилгээ

Эхний 9 сарын байдлаар эмнэлгийн нас баралтын 104 тохиолдол бүртгэгдсэнээс 46.8 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна.

Эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт

	Эдийн шинжилгээ	Эсийн шинжилгээ	Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт	Хийгдсэн задлан шинжилгээ		Амьгүй төрөлт	Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шгээ	Задлан шинжилгээ хийгээгүй	Задлан шинжилгээний хувь	Оношийн зөрүү тоо	Оношийн зөрүүний хувь
				Эмгэг судлалын	Шүүх эмнэлгийн						
2024 оны эхний 9 сарын байдлаар	1955	2194	90	48	6	3	0	36	58.1	3	6.3
2025 оны эхний 9 сарын байдлаар	1852	1909	104	37	12	5	2	55	46.8	0	0.0

Дөрөв.Халдварт өвчин

Аймгийн хэмжээнд 525 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 49.3 ногдож, өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор буурсан байна. 2025 оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний бүтцийг харахад нийт халдварт өвчний 56.2 хувийг амьсгалын замын халдвар эзэлж байгаагийн (43.4 нь салхинцэцэг, 20.7 хувийг сүрьеэ, 19.3 хувийг улаанбурхан, 12.5 хувийг гар хөл амны өвчин 4.1 хувийг гахай хавдар,) 25.0 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 13.7 хувийг бусад халдварт өвчин, 3.8 хувийг гэдэсний халдвар, 0.8 хувийг цусаар дамжих халдвар,0.6 хувийг зоонозын халдварт өвчин тус тус эзэлж байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 45.0 хувийг тэмбүү,38.2 хувийг трихомониаз, 16.8 хувийг заг хүйтэн тус тус эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 27 тохиолдол буюу 10 000 хүн амд 2.5 промиллоор нэмэгдэж, төрөлхийн тэмбүү 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Нийт халдварт өвчин 10 000 хүн амд

		2024 оны эхний 9 сарын байдлаар	2025 оны эхний 9 сарын байдлаар
Орхон аймаг	Нийт халдварт өвчин	543	525
	10 000 хүн амд	51.6	49.3
Улсын дүн	Нийт халдварт өвчин	29790	43602
	10 000 хүн амд	85.0	123.0

Халдварт өвчний тохиолдол, нас баралт, төрлөөр

Эхний 9 сарын байдлаар

№	Халдварт өвчин төрөл	Өвчлөл				Нас баралт			
		2024		2025		2024		2025	
		Тоо	10 000 хүн амд	Тоо	10 000 хүн амд	Тоо	10 000 хүн амд	Тоо	10 000 хүн амд
1	Амьсгалын замын халдварт өвчин	233	22.1	295	27.7	3	0.3	1	0.09
2	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	99	9.4	131	12.3				
3	Гэдэсний халдварт өвчин	33	3.1	20	1.9				
4	Зоонозын халдварт өвчин	1	0.09	3	0.3	1	0.09		
5	Цусаар дамжих халдварт өвчин	3	0.3	4	0.4				
6	Бусад халдварт өвчин	174	16.5	72	6.8				
Нийт халдварт өвчин		543	51.6	525	49.3	4	0.4	1	0.09

Амьсгалын замын халдварт өвчин

2025 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 295 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 56.2 хувийг эзэлж, амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 62 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Амьсгалын замын халдварт өвчний тохиолдол

